## ӨМНӨХ ҮГ

Манай статистикийн хэлтэс аймгийн эдийн засаг, нийгмийн байдлын талаарх энэхүү товхимолыг Үндэсний статистикийн хороонд мэдээлэгдэж буй болон албан ёсны статистикийн мэдээллийн хүрээнд боловсруулалт хийн бэлтгэж аймгийн удирдлага, хэрэглэгчдийн захиалгын үндсэн дээр тархааж байгаа болно.

Статистикийн мэдээ материалыг засах, хувилж олшруулах, тараахыг статистикийн хуулинд хориглосон учир хэрэглэгч та зөвхөн өөрийн үйл ажиллагаандаа ашиглах бөгөөд бичиж нийтлэх, илтгэл, сонсголд авч ашиглахдаа мэдээний эх сурвалжийг дурьдаж байхыг зөвлөе.

Манай мэдээллийг /www.nso.mn /portal/ сайтаас цахим хэлбэрээр авч болно. Харин товхимол хэлбэрээр авах тохиолдолд цаас хор, олшруулах зэрэг бэлтгэгдэх шууд зардлыг шингээсэн тодорхой өртөгтэй гардаг учир бид хэрэглэгчидтэйгээ харилцан үр ашигтай холбогдоно гэдэгт итгэж байна.

Манай энэ товхимол жил, улирал, сар тутамд тогтмол гардаг.

Энэхүү товхимолд орж буй мэдээллийн агуулга бүтцийг нийт хэрэглэгчдийн хэрэгцээг нийтлэг хангахуйцаар улам боловсронгуй болгох,алдаа дутагдал гарсан тохиолдолд засаж залруулах саналаа хэрэглэгч та бидэнд өгч байхыг хүсч байна.

ЖИЧ: Манайх тус хэлтэст байгаа улс, аймаг, сумын хүн ам, нийгэм, эдийн засгийн холбогдолтой тоо, мэдээ, материалын захиалгыг 1-ээс доошгүй хоногийн өмнө авч хэрэглэгчдийн захиалгын үндсэн дээр хүссэн үзүүлэлтээр бэлтгэн боловсруулалт хийж мэдээллээр үйлчилнэ.

**Хаяг:** Хэнтий аймгийн Нутгийн удирдлагын ордон 306, 307, 308 тоот өрөө

**Утас:** 70562303, 70562749, 70562348

## ХҮН АМ

Хүн амын тоо энэ оны эцэст 69.1 мянга болж, өнгөрсөн оноос 1.4 хувиар буюу 1017 хүнээр буурсан байна.

Нийт энэ онд манай аймагт 1.2 мянган хүн шилжин ирж, аймгаас 2.3 мянган хүн өөр аймаг хот руу шилжсэн байна. Шилжин явагсдын 77.0 хувийг Улаанбаатар хот руу шилжин явсан хүний тоо эзэлж байна. Аймагт нийт 21.8 мянган өрх амьдарч байгаа нь нэг өрхөд дундажаар 3.2 хүн ноогдож байна. Нийт өрхийн 26.0 хувь нь аймгийн төвд оршин сууж байна.

Энэ онд 257 хос гэрлэлтээ бүртгүүлснээс 16.7 хувь нь тайлант онд шинээр гэр бүл болсон байхад 2-4 жилийн өмнө гэр бүл болсон хос нь 38.9 хувийг эзэлж байна. Энэ онд нийт 48 хүн гэрлэлтээ цуцлуулж, 55 хүүхэд үрчлэгдсэн байна.

18 хүртэл насны бүтэн өнчин хүүхэд 116, хагас өнчин 929 хүүхэд байна. Хүүхэдтэй гэр бүлгүй эхийн тоо 1568, эцгийн тоо 256 болж, өмнөх оноосоо эхийн тоо 2.4 хувиар буурч, эцгийн тоо 24.9 хувиар өссөн байна.

## ТӨСВИЙН ОРЛОГО

2014 оны 03 дугаар сарын байдлаар төсвийн орлогод нийт 1744.1 сая төгрөг төвлөрөхөөс 1649.1 сая төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 95.0 сая төгрөг буюу 5.5 хувиар тасарсан байна.

Татварын бус орлогод төвлөрүүлэх ёстой 127.2 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө 51.1 хувиар буурч, төсөвт татварын бус орлогоор 62.3 сая төгрөг төвлөрсөн байна.

## ТӨСВИЙН ЗАРЛАГА

Орон нутгийн төсвийн байгууллага нийт 10753.0 сая төгрөгийн зарлагатай ажилласан нь төлөвлөснөөсөө 3250.3 сая төгрөгөөр бага зарцуулалттай ажилласан байна.

## ТӨСВИЙН ӨГЛӨГ АВЛАГА

2014 оны 03 сарын байдлаар төсөв 25.5 сая төгрөгийн авлагатай, 303.8 сая төгрөгийн өглөгтэй болсон байна.

Орон нутгийн төсвийн ажиллагсдад олгох цалингийн өглөг 134.7 сая төгрөг байгаа нь нийт өглөгийн 44.3 хувийг эзэлж байна.

## МӨНГӨ ЗЭЭЛ ХАДГАЛАМЖ

Банкны системийн хэмжээгээр өөрийн кассаар 40630.9 сая төгрөгийн орлогын, 60806.3 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийж орлогоороо зарлагынхаа 66.8 хувийг хангаж, арилжааны банкуудад 14733.0 сая төгрөг хүргүүлж, арилжааны банкуудаас 3017.7 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн.

Банкууд нь хадгаламжийн 30 төрлийн бүтээгдэхүүнээр үйлчилж 39908.9 сая төгрөгийн хадгаламж хуримтлуулж ажилласан байна.

Зээлийн өрийн үлдэгдэл 95097.6 сая төгрөгт хүрснээс чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 514.5 сая төгрөгт хүрч нийт зээлийн үлдэгдлийн 0.5 хувийг эзэлж байна.

ХААН, ХАС, КАПИТАЛ, ТӨР-ийн банкууд нь 50 нэр төрлийн зээлийн бүтээгдэхүүнийг жилийн 8-36 хувийн хүүтэйгээр олгож, иргэдийн хугацаатай хадгаламжинд жилийн 3-16 хувь, хугацаагүй хадгаламжинд жилийн 5.5-7.5 хувийн хүү олгож байна.

о Жич Банк санхүү зээлийн мэдээллийг Монгол банкны Хэнтий аймаг дахь салбар гаргав.

## ҮНЭ

2014 оны гуравдугаар сарын өргөн хэрэглээний бараа үйлчилгээний үнэ тариф 2010 оны 12 дугаар сар /суурь үе/-тай харьцуулсан индекс 147.0 хувь, өмнөх оны мөн үетэй харьцуулсан индекс 114.1 хувь, өмнөх сартай харьцуулсан индекс 109.0 хувь байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулсан үнийн индекс хэрэглээнд өндөр жин эзэлдэг бүтээгдэхүүн болох,гурил гурилан бүтээгдэхүүн 16.8 хувь өссөн, сүү сүүн бүтээгдэхүүн 2.7 хувь өссөн, мах махан бүтээгдэхүүн 14.8 хувь өссөн,чихэр цай жимс 14.6 хувь өссөн ,төмс хүнсний ногоо 6.9 хувь буурсан, хүнсний бусад бараа 8.7 хувь өссөн, архи ундаа тамхи 16.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулсан өөрчлөлт барааны бүлгийн дүнгээр хүнсний барааны үнийн индекс 13.8 хувь өссөн, хувцас гутал бөс бараа 18.3 хувь өссөн, орон сууц түлш 9.6 хувь өссөн, гэр ахуйн бараа 12 хувь өссөн, тээвэр холбооны үйлчилгээ 4.3 хувь өссөн, соёл боловсролын бараа үйлчилгээ 14.9 хувь өссөн , бусад бараа үйлчилгээний хувьд 20 хувь өссөн байна.

Өмнөх сартай харьцуулснаар барааны төрлөөр мах махан бүтээгдэхүүн 2.8 хувь өссөн, төмс хүнсний ногоо 4.6 хувь өссөн, сахар, чихэр, цай, жимс 3.1 хувь өссөн, архи, тамхи, ундаа 1.2 хувь өссөн, эмэгтэй хүний хувцас 1.9 хувь өссөн, хүүхдийн хувцас 1.3 хувь өссөн бусад барааны үнийн индекст өөрчлөлт ороогүй байна.

Барааны бүлгийн дүнгээр өмнөх сартай харьцуулахад хүнсний барааны үнийн индекс 1.6 хувь өссөн, хувцас, гутал, бөс бараа 0.6 хувь өссөн бусад бүлгийн дүнд өөрчлөлт ороогүй байна.

…Үнийн мэдээг 03 сарын 20-ны байдлаар гаргасан болно.

## ХӨДӨӨ АЖ АХУЙ

Энэ онд төллөвөл зохих хээлтэгч малын 15.8 хувь болох 211.0 мянга нь төллөж, гарсан төлийн 0.3 хувь болох 0.7 мянган төл хорогдож, 99.7 хувь буюу 210.3 мянган төл бойжиж байна. Оны эхний малын 0.2 хувь буюу 5.8 мянган толгой мал зүй бусаар хорогдсон нь ноднингийн мөн үеэс 1.2 мянган толгойгоор их байна.

## АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарт 28 аж ахуйн нэгж 30 гаруй иргэд үйл ажиллагаа явуулж, түүнд 500- гаад ажиллагсад ажиллаж байна. Аж үйлдвэрийн салбарын дүнгээр 2001,5 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1974,7 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулав.

Энэ онд өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 248,8 сая төгрөг буюу 14,2 хувь , борлуулалт 331,8 сая төгрөг буюу 20,2 хувиар тус тус өссөн байна.

Энэ сард үйлдвэрлэлийн салбарт 12 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн.

## ГЭМТ ХЭРЭГ

Цагдаагийн газрын мэдээгээр энэ онд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 125 болж, өмнөх оны мөн үеэс 5,9 хувиар өссөн байна. Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 6,4 хувийг танхайн, 44,8 хувийг иргэдийн өмчийн хулгайн хэргүүд эзэлж байна. Иргэдийн өмчийн хулгайн гэмт хэргийн 60,7 хувийг малын хулгай эзэлж байна. Гэмт хэргийн илрүүлэлт 44,6 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8,7 функтээр буурсан байна. Гэмт хэргийн улмаас нас барсан хүн 6 ба 45 хүн гэмтсэн. Байгууллага, иргэдэд 320,5 сая төгрөгийн хохирол учирсан байна. Гэмт хэргийн улмаас гарсан нийт хохирлын 61,1 хувь буюу 195,8 сая төгрөгийг нөхөн төлүүлсэн байна. Нийт гарсан гэмт хэргийн 42,4 хувь нь хөнгөн хэрэг , 46,4 хувь нь хүндэвтэр , 10,4 хувь нь хүнд гэмт хэрэг, 0,8 хувь нь онц хүнд гэмт хэрэг тус тус эзэлж байна,

Энэ сард 796 хүн эрүүлжүүлэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 2,9 хувь буюу 17 хүнээр өссөн байна.

## НИЙГМИЙН ДААТГАЛ

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр энэ улиралд 8403 тэтгэвэр авагчдад 5627,8 сая төгрөгийн тэтгэврийг олгоод байгаа нь тэтгэврийг хугацаанд нь бүрэн олгосон байна. Тэтгэмжийн даатгалын сангаас 669 хүнд 239,6 сая төгрөгийн тэтгэмж олголоо. Үүнд: 462 хүнд 29,6 сая төгрөгийн ХЧТА-ны тэтгэмж, 30 хүнд 48,9 сая төгрөгийн оршуулгын тэтгэмж, 177 эхэд 161,1 сая төгрөгийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг тус тус олгосон байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас эмчилгээний төлбөрт нийт 535,7 сая төгрөгийн санхүүжилт хийгээд байна. Үүнд: эмийн үнийн хөнгөлөлтөнд 24,7 сая төгрөгийг олголоо. Ажилгүйдлийн даатгалын сангаас 82 хүнд 56,4 сая төгрөгийн тэтгэмж олгоод байна.

## НИЙГМИЙН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Нийгмийн халамж үйлчилгээний байгууллагын мэдээгээр энэ улиралд нийгмийн халамжийн сангаас 15155 хүнд 2059,3 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлтийг олгосон байна. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад тэтгэвэр, тэтгэмж авагчдад олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 114,5 сая төгрөг буюу 5,9 хувиар өссөн байна. Нийт халамжийн сангийн 31,7 хувийг тэтгэвэрт, 57,9 хувийг тэтгэмж, 4,3 хувийг ахмад настан, тахир дутуу хүмүүст үзүүлэх хөнгөлөлтөд тус тус зарцуулсан байна.

## ЭРҮҮЛ МЭНД, СОЁЛ УРЛАГ

Эүүл мэндийн байгууллагын мэдээгээр энэ улиралд 398 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн оноос 1,0 хувиар буюу 4 хүүхдээр буурсан байна. Нэг хүртэлх насандаа 4 хүүхэд эндсэн .

Халдварт өвчнөөр 240 хүн өвчилсөн нь өнгөрсөн оноос 13,1 хувиар буюу 39 хүнээр буурсан байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн дотор трихомониазиар өвчлөгчид 16,2 , вируст гепатитаар өвчлөгчид 1,6, сүрьеэ өвчнөөр өвчлөгчид 11,2 , тэмбүү , хүйтэн өвчнөөр өвчлөгчид 33,3 хувийг тус тус эзэлж байна.

Энэ улиралд 90 хүн нас барсан нь өнгөрсөн оноос 21,6 хувиар өссөн байна. Нийт нас барсан хүний 20 хувь нь эмнэлэгт нас барсан байна. Эхний 3 сарын байдлаар хорт хавдраар 12 хүн нас барсан байна.

Соёл, урлагийн байгууллагууд 55,8 мянган хүнд үйлчлэн 11,2 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

## МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу эхний гурван сарын байдлаар төлөвлөгөөт 36, төлөвлөгөөт бус 50 нийт 86 хяналт шалгалтыг газрын даргын баталсан удирдамжаар хийв. Үүнээс хамтарсан хэлбэрээр 19, ахалсан хэлбэрээр 29, бие даасан байдлаар 57 удаа хийжээ.

Шалгалтанд нийт 530 эрсдэлтэй обьект хамрагдахаар төлөвлөснөөс 140 эрсдэлтэй обьект хамрагдаж, төсвийн 45, төрийн өмчийн оролцоотой 8, хувийн өмчийн болон салбар нэгжийн нийт 178 байгууллага, 217 иргэнийг хамруулан хяналт шалгалт хийсэн байна.

Шалгалтын явцад 914 зөрчил илэрсэн ба илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, арилгуулахаар улсын байцаагчид нийт 202 акт, 85 албан шаардлага үйлдэж, үйл ажиллагаанд 40, ажлын байранд 2 бүтээгдэхүүнд 53, дүгнэлт тус тус гаргасан байна.

Хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчил дутагдалд нийт 1351095,6 мянган төгрөгийн нөхөн төлбөр , торгууль шийтгэвэр ногдуулснаас 5762.8 мянган төгрөгийн нөхөн төлбөр хугацаа болоогүй, 2798.0 мянган төгрөгийн торгууль шиитгэврийг хугацаанд нь барагдуулж, 26000.0 мянган төгрөгийн нөхөн төлбөрийг хуулийн байгууллагад шилжүүлсэн байна.

Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын биелэлтийг хангаагүй нийт 4 байгууллага, аж ахуйн нэгж, объектын үйл ажиллагааг бүр болон зөрчлийг арилгах хүртэл түр хугацаагаар зогсоосон байна.

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, лавлагаа, мэдээллийн талаар**

2014 оны 1-р улиралд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлж үйлчилгээ хийлгэхээр гаргасан нийт 1486 ширхэг мэдүүлгийг хүлээн авч 1448-д үйлчилгээ хийсэн ба үүнээс төрөөс үнэгүй хувьчилсан орон сууцны баталгаажуулалт 10, газраас бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл 186, төрөөс үнэгүй хувьчилсан газрын өмчлөх эрхийн анхны баталгаажуулалт 343 тус тус бүртгэгдсэн байна.

Нийт бүртгэгдсэн гэрээ – 487 Үүнээс: Бэлэглэлийн гэрээ – 59, Худалдах худалдан авах гэрээ – 38, Өв залгамжлалын гэрээ –13, Хамтран өмчлөгч нэмэгдэх хасагдах хэлцэл – 54, Барьцааны гэрээ –323

## ТЭЭВЭР, ХОЛБОО

Оны эхний 03 сар 4107.4 мян тн км – ийн ачаа эргэлтээр 72.8 мянган тонн ачаа тээвэрлэж нийт орлого 174.9 сая төгрөгний орлого олжээ.

Аймгийн төвийн нийт нүүрсний татан авалт нь 72.7 мян тн, ачаа эргэлтээр 4071.2 мянган тонн нүүрс татан авчээ. Шуудан холбооны алба 4.6 мянган зорчигч тээвэрлэж 30.2 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

## БИЕ ХҮНД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Оны эхний 03 сард энэ салбарт 112,4 сая төгрөгний орлого орсны 9.0 хувийг үсчний, 2.6 хувийг зурагчны, 3.5 хувийг хог тээврийн, 20.6 хувийг халуун усны, 6.3 хувийг зочид буудлын, 58.0 хувийг зоогийн газрын орлого эзэлж байна

## АЖИЛГҮЙДЭЛ

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй, ажил идэвхтэй эрж байгаа ажилгүйчүүд тайлант сард 1105 байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8 хүнээр буюу 0,8 хувиар буурсан байна.

Нийт ажилгүйчүүдийн 25,0 хувь нь дээд, 6,7 хувь нь тусгай дунд, 9,4 хувь нь мэргэжлийн анхан шатны, 39,8 хувь нь бүрэн дунд, 13,2 хувь нь бүрэн бус дунд, 5,1 хувь нь бага боловсролтой, 0,8 хувь нь боловсролгүй хүмүүс байна.

Нийт ажилгүйчүүдийн 55,9 хувь нь эмэгтэйчүүд, 53,8 хувь нь 16-35 хүртэлх насны залуучууд байна. Нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 1,4 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.

## ШҮҮХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Энэ улиралд Шүүхийн байгууллага нь эрүүгийн 26 хэрэг шийлдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 19 хэрэгээр буюу 57,7 хувиар буурсан байна. Ял шийтгүүлсэн 42 хүний 2 нь эмэгтэй хүн байна.

Шийдвэрлэсэн иргэний хэрэг 120 шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 35 хэргээр буюу 22,6 хувиар буурсан байна.

# ТӨСВИЙН ОРЛОГО

/өссөн дүнгээр, мянган төгрөгөөр/

| | 2013.04.01 | 2014.04.01 | | |
|---|---|---|---|---|
| | | төлөвлөгөө | гүйцэтгэл | Хувь |
| Нийт орлого ба тусламжийн дүн | 20979331.5 | 4404745 | 4309689.7 | 0.98 |
| Урсгал орлого | 1053616.7 | 1681145 | 1619080.7 | 0.96 |
| Татварын орлого | 976691.6 | 1553897.7 | 1556793.8 | 1 |
| Орлогын албан татвар | 797507.5 | 1158954.7 | 1216047 | 1.05 |
| Хүн амын орлогын албан татвар | 797507.5 | 1158954.7 | 1216047 | 1.05 |
| Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого | 728688.6 | 1060600.5 | 1113309.7 | 1.05 |
| Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | 0 | 0 | 0 | |
| Хөрөнгө борлуулсаны орлого | 7352 | 16000 | 5583.5 | 0.35 |
| Үйл ажиллагааны орлогын | 38773 | 60414.4 | 73392.3 | 1.21 |
| Урлагын тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал | 1357.9 | 4197.1 | 559.2 | 0.13 |
| Орлогыг тодорхойлох боломжгүй иргэний | 21336 | 17742.7 | 23202.3 | 1.31 |
| Өмчийн татвар | 44537.9 | 37930.2 | 55972.7 | 1.48 |
| Үл хөдлөх хөрөнгийн албан татвар | 43211.9 | 36570.9 | 55050.7 | 1.51 |
| Бууны албан татвар | 1326 | 1359.3 | 922 | 0.68 |
| Дотоодын бараа, үйлчилгээний татвар | 18452.9 | 20670 | 16013.1 | 0.77 |
| Тусгай зориулалтын орлого | 18452.9 | 20670 | 16013.1 | 0.77 |
| Авто тээврийн болон өөрөө явагч | 18452.9 | 20670 | 16013.1 | 0.77 |
| Бусад татвар / төлбөр хураамж / | 116193.3 | 336342.8 | 268761.1 | 0.8 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 36052.1 | 33270.2 | 27192.8 | 0.82 |
| Газрын төлбөр | 26482.9 | 38267.2 | 25654.9 | 0.67 |
| Газрын төлбөр | 26482.9 | 13950.1 | 25654.9 | 1.84 |
| Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт | 0 | 24317.1 | 0 | 0 |
| Байгалын нөөц ашигласны төлбөр | 53658.3 | 199159.5 | 169633.2 | 0.85 |
| Ойн нөөц ашигласны төлбөр | 42275.3 | 31332.6 | 17852.8 | 0.57 |
| Ан амьтаны нөөц ашигласны төлбөр | 187 | 1684 | 392 | 0.23 |
| Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | 8355.3 | 166142.9 | 151388.4 | 0.91 |
| Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 1603.2 | 10273.4 | 4762.7 | 0.46 |
| Хог хаягдал үйлчилгээний хураамж | 1237.5 | 55372.5 | 41517.4 | 0.75 |
| Татварын бус орлого | 56925.1 | 127247.3 | 62286.8 | 0.49 |
| Хүү, торгуулийн орлого | 54234.7 | 107987.3 | 47506.8 | 0.44 |
| Бусад нэр заагдаагүй орлого | 2690.4 | 19260 | 14780 | 0.77 |
| Хөрөнгийн орлого | 29088.9 | 63000 | 30009 | 0.48 |
| Хөрөнгө худалдсаны орлого | 29088.9 | 63000 | 30009 | 0.48 |
| Тусламжийн орлого | 19896625.9 | 2660600 | 2660600 | 1 |
| Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг | 2327600 | 2660600 | 2660600 | 1 |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 7107898.8 | 0 | 0 | |
| Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн | 1095372.8 | 0 | 0 | |
| Аймаг нийслэлээс авсан санхүүгийн | 916656 | 0 | 0 | 0 |

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРЛАГА

/ өссөн дүнгээр, мянган төгрөг/

| | 2013.04.01 | 2014.04.01 | | Төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүү | *Өглөг* |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| I. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 9737248.4 | 14003341.5 | 10753044 | 3250297.6 | ***303820.5*** |
| 1.1. Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 5033660 | 5825766.3 | 5358950.9 | 466815.4 | ***134704.3*** |
| Үндсэн цалин | 4590828 | 5178857.7 | 4921366.5 | 257491.2 | ***132443.3*** |
| Нэмэгдэл цалин | 33800.2 | 75817.1 | 61960.8 | 13856.3 | |
| Гэрээт ажлын цалин | 209501.6 | 277360.5 | 242799.3 | 34561.2 | ***2261.0*** |
| Унаа хоолны хөнгөлөлт | 9969.1 | 12365.4 | 8334.7 | 4030.7 | |
| Үр дүнгийн урамшуулал | 189561.1 | 281365.6 | 124489.6 | 156876 | |
| 1.2 Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл | 539326.1 | 641683 | 580227.1 | 61455.9 | ***34599.8*** |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол | 1055462.8 | 1267809.5 | 1131945.3 | 135864.2 | ***105217.2*** |
| Гэрэл цахилгаан | 102613.5 | 109634.8 | 124965.7 | -15330.9 | ***5931.2*** |
| Түлш халаалт | 911239.2 | 1091335.7 | 970979.2 | 120356.5 | ***94450.1*** |
| Цэвэр, бохир ус | 40955.8 | 66370.4 | 36000.5 | 30369.9 | ***4825.9*** |
| Байрны түрээс | 654.3 | 468.6 | 0 | 468.6 | |
| Хангамж бараа материалын зардал | 188826.6 | 260446.7 | 211997.6 | 48449.1 | ***11585.9*** |
| Бичиг хэрэг | 15441.7 | 26072 | 20761.1 | 5310.9 | ***3804.6*** |
| Тээвэр /шатахуун/ | 135119.1 | 159461.3 | 147012.7 | 12448.6 | ***7168.3*** |
| Шуудан, холбоо | 14632.2 | 31625.2 | 17879.7 | 13745.5 | ***274.6*** |
| Ном хэвлэл авах | 5615.7 | 13523.1 | 5783.6 | 7739.5 | ***147.6*** |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9738.2 | 12749.9 | 7199.6 | 5550.3 | |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 8279.7 | 17015.2 | 13360.9 | 3654.3 | ***190.9*** |
| Нормативт зардал | 406876.1 | 776114.2 | 559104.3 | 217009.9 | ***4855.3*** |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10849.6 | 29262.6 | 14000.4 | 15262.2 | ***520.0*** |
| Хоол | 355910.3 | 701677.2 | 505644.1 | 196033.1 | ***164.8*** |
| Эм | 40116.2 | 45174.4 | 39459.8 | 5714.6 | ***4170.5*** |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 41059.6 | 84321.5 | 42391.6 | 41929.9 | ***7495.9*** |
| Багаж, техник, хэрэгсэл | 0 | 350 | 0 | 350 | |
| Тавилга | 11742 | 39871.5 | 18976.9 | 20894.6 | |
| Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 0 | 337.5 | 0 | 337.5 | |
| Урсгал засвар | 29317.6 | 43762.5 | 23414.6 | 20347.9 | ***7495.9*** |
| Томилолт зочны зардал | 35878 | 62269.1 | 40675.8 | 21593.3 | ***3597.3*** |
| Дотоод албан томилолт | 35878 | 55028.5 | 35675.8 | 19352.7 | ***3597.3*** |
| Гадаад албан томилолт | 0 | 7240.6 | 5000 | 2240.6 | |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж | 29470 | 339715.8 | 77386.2 | 262329.6 | ***834.1*** |
| Уран бүтээл хийлгэх хийлгэх | 4940.6 | 12910 | 2879.8 | 10030.2 | ***179.6*** |
| Төлбөр хураамж болон бусад | 9963.9 | 68898.4 | 11177.7 | 57720.7 | ***654.5*** |
| Холбооны суваг ашигласны хөлс | 3132.9 | 5044.2 | 2633.2 | 2411 | |
| Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал | 406.4 | 27000 | 23054 | 3946 | |
| Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ | 0 | 43205.6 | 0 | 43205.6 | |
| Харуул хамгаалалтын хөлс | 606.5 | 1360.5 | 445.1 | 915.4 | |
| Мал эмнэлгийн үйлчилгээний | 0 | 105000 | 0 | 105000 | |
| Төрийн нэрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ | 8186 | 46721.5 | 33540.8 | 13180.7 | |
| Аудит,баталгаажуулалт зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс | 376 | 3943.6 | 228.5 | 3715.1 | |
| Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 10 | 108.6 | 1132.4 | -1023.8 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Даатгалын үйлчилгээ | 0 | 16763 | 0 | 16763 | |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | 0 | 2532.5 | 482.2 | 2050.3 | |
| Мэдээлэл сурталчилгааны зардал | 1817.8 | 5277.7 | 1775.5 | 3502.2 | |
| Газрын төлбөр | 30 | 0 | 0 | 0 | |
| Тээврийн хэрэгслийн татвар | 0 | 950.2 | 37 | 913.2 | |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 268459.7 | 457467.5 | 307027.7 | 150439.8 | ***824.0*** |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага, сургуулилт | 34173.4 | 75706 | 54790 | 20916 | ***617.3*** |
| Биеийн тамирын уралдаан тэмцээн | 10073.9 | 15925.9 | 8674.1 | 7251.8 | |
| Орон нутгийн нөөц хөрөнгө | 107862.2 | 261450 | 158283.9 | 103166.1 | ***206.7*** |
| Хөтөлбөр болон төслийн дотоод урсгал зардал | 64842.1 | 23864.6 | 14660.5 | 9204.1 | |
| Нэг иргэнд ноогдох нормативаар тооцсон зардал | 51508.1 | 80521 | 70619.3 | 9901.7 | |
| Засгийн газрын дотоод шилжүүлэг | 6966.3 | 29250 | 26199.8 | 3050.2 | |
| ИТХ-д суудалтай намд төсвөөс өгөх | 6966.3 | 29250 | 26199.8 | 3050.2 | |
| Нийгмийн халамжийн үйлчилгээ | 1168217.2 | 1306000 | 1284825.1 | 21174.9 | |
| Ажил олгогчоос олгох тэтгэмж, нэг удаагийн урамшуулал | 430296.8 | 770182.7 | 702442.3 | 67740.4 | ***106.7*** |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 214942.5 | 99753.7 | 61508.8 | 38244.9 | |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал | 12300.5 | 27766.2 | 11001.2 | 16765 | ***106.7*** |
| Бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмж | 0 | 193431.7 | 187147.9 | 6283.8 | |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 203053.8 | 449231.1 | 442784.5 | 6446.6 | |
| Төрөөс иргэдэд үзүүлэх бусад тэтгэмж, дэмжлэг | 113362 | 216215.2 | 149582.1 | 66633.1 | |
| Үдийн цай хөтөлбөр | 113362 | 216215.2 | 149582.1 | 66633.1 | |
| Хөрөнгө оруулалт | 402824.4 | 1943600 | 262653.6 | 1680946.4 | |
| Орон нутгийн хөрөнгө оруулалт, их засвар | 402824.4 | 1943600 | 262653.6 | 1680946.4 | |
| Бусад | 13059.4 | 22500 | 17634.2 | 4865.8 | |
| Гудамжны гэрэлтүүлэг | 13059.4 | 22500 | 17634.2 | 4865.8 | |
| Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр | 0 | 14003341.5 | 12545274 | 1458067.9 | |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос | 0 | 37536.5 | 110446 | -72909.5 | |
| Туслах үйл ажиллагааны орлогоос | 0 | 24105.9 | 4757.4 | 19348.5 | |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс | 0 | 7967223.4 | 7967223.4 | 0 | |
| Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрээс санхүүжих | 0 | 1498600 | 555080.6 | 943519.4 | |
| Төсвийн хөрөнгөөр санхүүжих | 0 | 4404745 | 3907766.1 | 496978.9 | |
| Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1166321.5 | 0 | 2498183.8 | 0 | |
| Нэр данс зөрүүтэй орлого | 0 | 0 | -5538.1 | 0 | |

## МӨНГӨ, ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2013.04.01 | 2014.04.01 | Үүнээс: | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Монгол банк | ХААН банк | Төрийн банк | Капитал банк | ХАС банк |
| Кассын орлого /зузаатгалаар/ | 8782000.0 | 14733000.0 | 0.0 | 10956000.0 | 2847000.0 | 100000.0 | 830000.0 |
| Кассын цэвэр орлого | 55878019.9 | 40630947.4 | 355.7 | 26035600.3 | 11483155.2 | 244285.0 | 2867551.2 |
| Кассын зарлага /шилжүүлэг/ | 1017607.0 | 3017670.0 | 0.0 | 913030.0 | 2001090.0 | 0.0 | 103550.0 |
| Кассын цэвэр зарлага | 64946741.1 | 60806261.2 | 1300.3 | 44745102.3 | 13064637.6 | 221313.6 | 2773907.4 |
| Зээлийн өрийн үлдэгдэл | 72745131.0 | 95097619.8 | 0.0 | 58966154.9 | 23584352.0 | 225654.0 | 12321458.9 |
| Чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл | 180687.5 | 514517.1 | 0.0 | 354000.9 | 23298.9 | 0.0 | 137217.3 |
| Хадгаламжийн үлдэгдэл | 29791687.5 | 39908957.1 | 0.0 | 22167102.5 | 12298026.0 | 4871.6 | 5438957.0 |
| Үүнээс: Хугацаатай | 22497232.6 | 27654981.9 | 0.0 | 14682935.1 | 8553041.0 | 3936.0 | 4415069.8 |
| Хугацаагүй | 7294454.9 | 12253975.2 | 0.0 | 7484167.4 | 3744985.0 | 935.6 | 1023887.2 |

*ГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС*

| БАРААНЫ БҮЛГЭЭР | 2014.III | 2014.III | 2014.III |
|---|---|---|---|
| | 2010.XII | 2013.III | 2014.II |
| **ХҮНСНИЙ БАРАА** | 1420.0 | 113.8 | 101.6 |
| Гурил, гурилан бүтээгдхүүн | 112.3 | 116.8 | 100.0 |
| Мах, махан бүтээгдхүүн | 207.9 | 114.8 | 102.8 |
| Сүү, сүүн бүтээгдхүүн | 141.1 | 102.7 | 100.0 |
| Саахар, чихэр, цай, жимс | 123.7 | 114.6 | 103.1 |
| Төмс, хүнсний ногоо | 105.1 | 106.9 | 104.6 |
| Хүнсний бусад бараа | 116.3 | 108.7 | 100.0 |
| Архи, ундаа, тамхи | 194.7 | 116.8 | 101.2 |
| **ХУВЦАС,ГУТАЛ, БӨС БАРАА** | 152.6 | 118.3 | 100.6 |
| Эрэгтэй хүний хувцас | 131.1 | 127.6 | 100.0 |
| Эмэгтэй хүний хувцас | 148.7 | 107.3 | 101.9 |
| Хүүхдийн хувцас | 224.7 | 140.2 | 101.3 |
| Гутал | 145.3 | 115.5 | 100.0 |
| Хөвөн, бөс бараа | 182.1 | 120.2 | 100.0 |
| **ОРОН СУУЦ, ТҮЛШ, ЦАХИЛГААН** | 145.6 | 109.6 | 100.0 |
| **ГЭР АХУЙН БАРАА** | 195.2 | 112.0 | 100.0 |
| **ЭМ ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ** | 130.6 | 100.0 | 100.0 |
| **ТЭЭВЭР, ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ** | 125.8 | 104.3 | 100.0 |
| **СОЁЛ, БОЛОВСРОЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ** | 130.8 | 114.9 | 100.0 |
| **БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ** | 197.7 | 120.0 | 100.0 |
| **ЕРӨНХИЙ ИНДЕКС** | 147.0 | 114.1 | 109.0 |

## ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ

/төгрөг/

| Үзүүлэлт | 2013.04.01 | 2014.04.01 | Өөрчлөлт /+; -/ |
|---|---|---|---|
| Гурил 1-р зэрэг | 900 | 1000 | 100 |
| Хонины мах, кг | 7500 | 7500 | 0 |
| Үхрийн мах, кг | 8500 | 9500 | 1000 |
| Ямааны мах, кг | 6500 | 6500 | 0 |
| Элсэн чихэр, кг | 1600 | 1600 | 0 |
| Цагаан будаа, кг | 1600 | 2200 | 600 |
| Шингэн сүү, л | 1500 | 1500 | 0 |
| Ноолуур, кг | 68000 | 86000 | 18000 |
| Бензин, А-80, 1 литр | 1620 | 1590 | -30 |
| Бензин, А-92, 1 литр | 1850 | 1840 | -10 |
| Дизель түлш, 1 литр | 1910 | 1900 | -10 |

## Том малын зүй бусын хорогдол

| № | | 2012 оны эцэст бэлэн тоологдсон мал | 2013.04.01 | | 2014.04.01 | | Зөрүү /+,-/ | 2013 оны эцэст бэлэн тоологдсон мал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Нийт хорогдол | Оны эхний малд эзлэх хувь | Нийт хорогдол | Оны эхний малд эзлэх хувь | | |
| | **Малын төрлөөр** | | | | | | | |
| | Тэмээ | 3671 | 0 | 0.0 | 2 | 0.1 | 2 | 3586 |
| | Адуу | 172578 | 269 | 0.2 | 479 | 0.2 | 210 | 195587 |
| | Үхэр | 182734 | 296 | 0.2 | 901 | 0.4 | 605 | 207180 |
| | Хонь | 1277747 | 1790 | 0.1 | 2057 | 0.1 | 267 | 1408743 |
| | Ямаа | 973657 | 2194 | 0.2 | 2328 | 0.2 | 134 | 1060238 |
| | **Бүгд** | **2610387** | **4549** | **0.2** | **5767** | **0.2** | **1218** | **2875334** |
| | **Сумаар** | | | | | | | |
| 1 | Галшар | 207243 | 41 | 0.0 | 450 | 0.2 | 409 | 232272 |
| 2 | Баянхутаг | 238532 | 147 | 0.1 | 1 | 0.0 | -146 | 275144 |
| 3 | Баянмөнх | 105138 | 35 | 0.0 | 0 | 0.0 | -35 | 122442 |
| 4 | Дархан | 142422 | 85 | 0.1 | 104 | 0.1 | 19 | 158142 |
| 5 | Дэлгэрхаан | 154609 | 22 | 0.0 | 67 | 0.0 | 45 | 178544 |
| 6 | Жаргалтхаан | 154152 | 96 | 0.1 | 851 | 0.5 | 755 | 165633 |
| 7 | Цэнхэрмандал | 141769 | 358 | 0.3 | 324 | 0.2 | -34 | 149947 |
| 8 | Өмнөдэлгэр | 332559 | 1072 | 0.3 | 1499 | 0.4 | 427 | 349653 |
| 9 | Батширээт | 48693 | 111 | 0.2 | 125 | 0.2 | 14 | 50544 |
| # | Биндэр | 129039 | 253 | 0.2 | 262 | 0.2 | 9 | 138720 |
| # | Баян-Адарга | 77302 | 110 | 0.1 | 319 | 0.4 | 209 | 86571 |
| # | Дадал | 27586 | 60 | 0.2 | 105 | 0.3 | 45 | 30529 |
| # | Норовлин | 93862 | 251 | 0.3 | 194 | 0.2 | -57 | 96202 |
| # | Батноров | 244204 | 594 | 0.2 | 694 | 0.3 | 100 | 265080 |
| # | Баян-Овоо | 89494 | 514 | 0.6 | 9 | 0.0 | -505 | 96008 |
| # | Мөрөн | 143736 | 122 | 0.1 | 595 | 0.4 | 473 | 154991 |
| # | Хэрлэн | 229085 | 69 | 0.0 | 121 | 0.0 | 52 | 262777 |
| # | Бор-өндөр | 50962 | 609 | 1.2 | 47 | 0.1 | -562 | 62135 |

## Төллөлт,төл бойжилт

| № | | 2013.04.01 | | | | 2013 оны эцсийн хээлтэгчийн тоо | 2014.04.01 | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төллөлтийн хувь | Хорогдсон төл | Бойжсон төл | Бойжилтын хувь | | Төллөлтийн хувь | Хорогдсон төл | Бойжсон төл | Бойжилтын хувь |
| | **Малын төрлөөр** | | | | | | | | | |
| | Тэмээ | 3.5 | 0 | 100 | 100.0 | 1296 | 0.0 | 1 | 148 | 99.3 |
| | Адуу | 1.2 | 13 | 1629 | 99.2 | 58666 | 0.0 | 26 | 4685 | 99.4 |
| | Үхэр | 7.0 | 43 | 4577 | 99.1 | 81179 | 0.0 | 63 | 9473 | 99.3 |
| | Хонь | 3.5 | 170 | 60931 | 99.7 | 691427 | 0.0 | 300 | 10950 | 97.3 |
| | Ямаа | 3.5 | 173 | 45447 | 99.6 | 504177 | 0.0 | 344 | 86470 | 99.6 |
| | **Бүгд** | **3.6** | **399** | **112684** | **99.6** | **1336745** | **0.0** | **734** | **210276** | **99.7** |
| 1 | Галшар | 5.7 | 0 | 14611 | 100.0 | 103021 | 0.0 | 0 | 29864 | 100.0 |
| 2 | Баянхутаг | 0.2 | 0 | 1146 | 100.0 | 130260 | 0.0 | 0 | 419 | 100.0 |
| 3 | Баянмөнх | 2.2 | 11 | 11129 | 99.9 | 58498 | 0.0 | 3 | 16595 | 100.0 |
| 4 | Дархан | 3.3 | 0 | 12856 | 100.0 | 71943 | 0.0 | 0 | 25404 | 100.0 |
| 5 | Дэлгэрхаан | 3.1 | 0 | 4329 | 99.9 | 80425 | 0.0 | 0 | 28691 | 100.0 |
| 6 | Жаргалтхаан | 1.4 | 0 | 2805 | 100.0 | 76838 | 0.0 | 0 | 1649 | 100.0 |
| 7 | Цэнхэрмандал | 3.6 | 0 | 14054 | 100.0 | 70578 | 0.0 | 136 | 10729 | 98.7 |
| 8 | Өмнөдэлгэр | 5.0 | 178 | 6096 | 97.2 | 172249 | 0.0 | 458 | 13625 | 96.7 |
| 9 | Батширээт | 12.4 | 50 | 1626 | 97.0 | 21637 | 0.0 | 15 | 1564 | 99.1 |
| 10 | Биндэр | 3.4 | 0 | 2744 | 99.7 | 62487 | 0.0 | 0 | 1806 | 99.7 |
| 11 | Баян-Адарга | 3.6 | 0 | 2934 | 100.0 | 40532 | 0.0 | 12 | 5800 | 99.8 |
| 12 | Дадал | 32.1 | 0 | 753 | 100.0 | 13554 | 0.0 | 5 | 1279 | 99.6 |
| 13 | Норовлин | 6.1 | 34 | 2876 | 98.8 | 43667 | 0.0 | 52 | 6900 | 99.3 |
